

Өлгий сумын ЗДТГ-ын 12-р сарын 28-с эхлэн 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл

2019-01-03

- Төв талбайг чимэглэн, шинэ жилийн сүлд модыг босгож 12 жилийг мөсөөр хийх ажлыг байгууллагуудтай хамтарч гүйцэтгэн сүлд мод жилүүдийг гэрэлтүүлэгтэй болгох ажил хийв.
- Өлгий хотод цас орсонтой холбогдуулан халтиргаа гулгаа үүсгэхгүйн тулд 3 удаа замд давс цацах ажил хийж нийт 2,5 тн давс цацав.
- 2018 оны жилийн эцсийн байдлаар хүн ам малын тооллого хийгдсэн, Өлгий сумын хэмжээнд нийт 37980 хүн тоологдсон нийт 8602 өрх бүргэгдсэн. Малын тоо 24662, үүнээс тэмээ-38, адуу-1178, үхэр-5624, хонь-6372, ямаа-11450
- Багийн засаг дарга нар цэргийн үүрэгтний судалгааг гаргаж ажиллаж байна.
- 2018 онд ЗДТГазраас хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээ, тайлан судалгааг гаргаж, холбогдох хэлтэс агентлагт хүргүүлэв.
- Байгууллагын сүлд модны цэнгүүнийг зохион байгуулж, сумын оны шилдэгүүдийг шалгаруулав.
- Байгууллагын ажилтан, албан хаагч нарт өргөтгөсөн хурал хийж, шинэ онд цаашид хийж гүйцэтгэх ажил болон төлөвлөгөө боловсруулах талаарх үүрэг даалгавар өгч ажиллаж байна.
- Аймгийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу оны эцсийн санхүүгийн тайланг хугацаанд гаргаж өгөх талаар сумын санхүүгийн албанд ажлын чиглэл өгсөн болно.
- Ард иргэдээс ирсэн мэдээллийн талаар Цамбагарав-2 дэлгүүрт болон СУАТ ХХК-ны үйл ажиллагааг таслан зогсох талаар БОХУБайцаагчын мэдэгдэх хуудсыг хүргүүлэн, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.
- Ах дам захын хойд талын авто зогсоолд үйлчилгээ үзүүлдэг таксийн үйлчилгээ эрхлэгчдийн хүсэлтийн дагуу газрын асуудлыг холбогдох хяналтын байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэв.
- Хүүхэд харах үйлчилгээ эрхэлдэг иргэдийн материалыг хүлээн авч, сунгуулах талаар судалгаа хийж байна.
- Хүүхэд үрчлүүлэх иргэдийн материалыг хүлээн авч дүгнэлт гаргуулах талаар санал боловсруулж, судалгаа хийж байна.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ